



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Коронавируст халдварыг илрүүлэх
оношлуурын хэрэглээг тандан судлах
ажлын хэсгийн тушаал

Монол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Коронавируст халдварыг илрүүлэх оношлуурын хэрэглээг тандан судлах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар, ажлын хэсгийн төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тандалт судалгааг хийх ажлын хэсгийг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Пүрэвжав)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газарт тус тус үүрэг болгосугай.

3.Тандалт судалгааны тайланг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр явцын тайланг танилцуулж, II улиралд багтаан боловсруулж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн дарга (Б.Пүрэвжав)-д даалгасугай.


ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 0.4 дугаар сарын 22-ны
өдрийн 17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

83



КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ ОНОШЛУУРЫН ХЭРЭГЛЭЭГ
ТАНДАН СУДЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Б.Пүрэвжав (Эмийн аюулгүй байдлын
тандалт, судалгааны газрын дарга)

Гишүүд: Б.Ганпүрэв (Эм, биобэлдмэлийн улсын
байцаагч)

Ц.Амаржаргал (Эмийн бүртгэлийн хэлтсийн
мэргэжилтэн)

Б.Бумдэлгэр (ЭМЯ-ны Лабораторийн
мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн)
(зөвшилцсөнөөр)

Г.Цогзолмаа (ХӨСҮТ-ийн Нэгдсэн
лабораторийн Вирус судлалын лабораторийн
эмч) (зөвшилцсөнөөр)

Э.Баттөмөр (ХӨСҮТ-ийн Нэгдсэн
лабораторийн албаны Биоаюулгүй
ажиллагааны менежер) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: М.Долгион (Эмийн аюулгүй байдлын тандалт,
судалгааны газрын мэргэжилтэн)

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 04 дугаар сарын 22-ны
өдрийн 483 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ ОНОШЛУУРЫН ХЭРЭГЛЭЭГ ТАНДАН СУДЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл.

Дэлхий нийтээрээ Коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээг улс орон бүр өөр, өөрийн орны онцлог, хүчин чадал, хүн ам зүйн нөхцөл байдалд тулгуурлан хийж байна.

Манай Улсад дотоодын халдвар тархсан 2020 оны 11 дүгээр сараас хойш коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээг эрчимтэй хийж гүйцэтгэж байгаа.

Цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэй бодит хугацааны Полимеразийн гинжин урвалын шинжилгээний оношлуурын хомсдол дэлхий дахины үүссэн нь одоо хүртэл үргэлжилж байгаа.

Импортын бүтээгдэхүүнийг орлохуйц дараах монгол эрдэмтдийн шинэ бүтээлийг бодлогоор дэмжих нь зүйтэй.

Монгол Улсад шинэ бүтээлийн патентын эрх бүхий Коронавируст халдвар SARS-CoV-2 вирусийг илрүүлэхэд ашиглах бодит хугацааны Полимеразийн гинжин урвалын аргад үндэслэсэн праймер пробын дараалал, урвуу транскриптазит SARS-CoV-2 вирусийг илрүүлэх бодит хугацааны полимеразийн гинжин урвалын цомог оношлууруудад зохицуулалтын байгууллагаас дэмжлэгт үнэлгээ хийж, инновацийн шинэ бүтээлийг бодлогоор дэмжих зайлшгүй шаардлага тулгарлаа.

Иймд Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн СиФорЭЙ, Чорос-Онош байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцахаар болсон.

Хоёр. Зорилго.

Үндэсний инноваци шингэсэн оношлуурт зах зээлийн хэрэгцээг судалж, тандалт, дэмжлэгт үнэлгээ хийх.

Гурав. Зорилт

1. Асуумж бүхий үнэлгээний хуудсаар үнэлгээ хийх;
2. Зах зээлд хэрэглэсэн оношлуурын хэрэглээнд тандалт хийх;

Дөрөв. Хамтран ажиллах байгууллага.

Эрүүл мэндийн яамны Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл

Халдварт Өвчин Судлалын Үндэсний төв

Тав. Хугацаа.

2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 29-ны өдөр.

Зургаа. Хүрэх үр дүн.

Үндэсний инноваци шингэсэн оношлуур бүтээх үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж чиглэл тус бүрээр дэмжлэгт үнэлгээ хийж, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгсөн байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн 4/83 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ ХЭРЭГЛЭХ ОНОШЛУУРЫН ХЭРЭГЛЭЭГ ТАНДАН СУДАЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтаны нэр
1.	ДЭМБ-ын шалгуур үзүүлэлт бүхий асуумжийг орчуулах	2022.04.22-23	Ажлын хэсэг
2.	Бүртгэлийн архивын материалтай танилцах	2022.04.22- 04.25	Ажлын хэсэг
3.	Үйл ажиллагаагаатай газар дээр нь танилцаж ажиллах	2022.04.25-27	Ажлын хэсэг
4.	Тандалт судалгааны үр дүнг нэгтгэх	2022.04.26-28	Ажлын хэсэг
5.	Тайланг удирдлагад танилцуулах	2022.04.29	
6.	Тандалт судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, сайжруулах чиглэлд цаашид авах арга хэмжээний саналыг хүргэх	2022.05.02-12	